



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА  
Э.ЭРДЭНЭСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.01.10 № 05/248  
танай 2018.12.31-ны № 1/370 -г


Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Оюуны өмчийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Очирын Амарбат, мөн газрын Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Мягмарсүрэнгийн Сумъяа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллагын албан тушаалтанд гаргаж мэдүүлэх үүрэгтэй бөгөөд мөн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Харин шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4-т "жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх" гэж заасан байх тул нэр дэвшигч М.Сумъяаг төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн эсэх талаар Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлтийг авч тухайн албан тушаалд томилох эсэх асуудлыг шийдвэрлэнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

  
Х.ХАШБААТАР

0000228